

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2020 ОНЫ 05 ДУГААР САРЫН МЭДЭЭ

Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Засгийн газрын 149 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах үүднээс Харилцаа холбоо мэдээлэл технологийн газартай хамтран 2020 оны 05 дугаар сарын 05-ны 20 сумын операторт сургалт мэдээлэл өгч, тоног төхөөрөмжийг гардуулсан. Одоогоор 7 сум төрийн үйлчилгээнд операторийн үйлчилгээг үзүүлж эхлээд байна.

2020 оны 05 дугаар сарын 15-ны өдөр дэс түшмэлийн ангиллын гүйцэтгэх албан тушаалын 5 сул ажлын байрны тусгай шалгалт, 2020 оны 06 дугаар сарын 04-ний өдөр төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийн 8 ажлын байрны сонгон шалгаруулалтыг зохион байгуулав.

Аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх "Хөгжлийн хөтөч" үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнгээр 4 нэвтрүүлгийг бэлтгэж иргэд олон нийтэд цахимаар болон орон нутгийн телевизээр дамжуулан хүргэлээ.

Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд:

Төрийн сангийн төлбөр тооцооны программаар 2020 оны 05-р сард 46 Төсөвт байгууллагын үндсэн болон нэмэлт санхүүжилтийн данснаас 6.2 тэр бум төгрөгний **1,727** ширхэг гүйлгээ шивэгдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн 2020 оны 4-р сарын мэдээгээр Орон нутгийн орлого, санхүүжилт 3,522.8 сая төгрөгний төлөвлөгөөтэйгээс 3,982.5 сая төгрөг буюу 113,0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн болон тусгай шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарлагын гүйцэтгэл батлагдсан төсөв 39,977.9 сая төгрөг байгаа бөгөөд үүнээс 22,981.5 сая төгрөг нь тусгай зориулалтын шилжүүлгээс, 7,436.3 сая төгрөг нь орон нутгийн байгууллагуудад олгох санхүү дэмжлэг болон аймаг сумын орлогоос, 243.4 сая төгрөг нь төсөвт байгууллагын өөрийн орлогоос, 1,301.7 сая төгрөг нь орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас тус тус санхүүжигдсэн байна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээнд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр 39,977.9 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 33,169.2 мянган төгрөг буюу 83.0 % хувьтай байна. ТЗШ-ын санхүүжилт болон санхүүгийн дэмжлэг бүрэн ирсэн. ОНХС-ийн санхүүжилт дутуу ирсэн. Үндсэн үйл ажиллагааны орлого өндөр давалттай байна..

Төсвийн гүйцэтгэлийн мэдээгээр Төсвийн нийт авлага **4,170.3** сая төгрөг өмнөх сараас **873.6** сая төгрөгөөр өссөн байна.

Нийт өглөг **1,113.5** сая төгрөг өмнөх сараас **78.6** сая төгрөгөөр өссөн байна.

2020 оны 05 сарын байдлаар $\text{төлөвлөгөөний нийт}$ шимтгэлийн орлого 2201.9 төг , $\text{төлөвлөгөөний хувь}$ 103.7 төг $\text{төлөвлөгөөний хувь}$ 100.2 % - $\text{төлөвлөгөөний хувь}$ байна.

Төлөвлөгөөг сан тус бүрээр нь харуулбал:

/Сая.төг/

Төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
Тэтгэвэр	1980.1	1982.3	100.1
Тэтгэмж	177.3	180.1	101.6
Үомшө	111	111.3	100.3
ЭМД	0,0	0,0	0,0
ажилгүйдэл	32.4	31.9	98.5
дүн	2300.8	2305.6	100.2

Түрэмгий $\text{төлөвлөгөөний нийт}$ 19420 төг $\text{төлөвлөгөөний хувь}$ 6460.2 төг $\text{төлөвлөгөөний хувь}$ 4 $\text{төлөвлөгөөний хувь}$ $\text{төлөвлөгөөний хувь}$ 190 $\text{төлөвлөгөөний хувь}$ 165.9 төг $\text{төлөвлөгөөний хувь}$ $\text{төлөвлөгөөний хувь}$ 81 $\text{төлөвлөгөөний хувь}$ 44.3 төг $\text{төлөвлөгөөний хувь}$ $\text{төлөвлөгөөний хувь}$.

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 517.7 сая төгрөг байна.

Гурав. Хууль эрхзүйн бодлогын хүрээнд :

Аймгийн Мэргэжлийн хяналтын газраас МХЕГ-ын даргын 01/69 дугаартай ундны усны чанар, аюулгүй байдалд хяналт шинжилгээ хийх удирдамжийн дагуу 17 сумын иргэн аж, ахуй нэгж байгууллагын гүний худаг, гол мөрөн, болон Хөвсгөл нуурын усны цэвэршилтийг тогтоох зорилгоор 10 цэгээс дээж авч, шинжилгээнд хамрууллаа. Сумдын ундны усны хяналт шинжилгээний хамрагдалт 73,8 хувьтай байна.

МХЕГ-ын даргын 01/13 тоот удирдамжийн дагуу Мөрөн сумын 2 хүнсний зах, 12 худалдаа, үйлчилгээ, 6 нийтийн хоолны газрыг хамруулан хяналт шалгалт хийж, газар дээр нь мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хүнсний бүтээгдэхүүний чанар, хадгалах хугацаа, нөхцөл, ажиллагсадын маск, гар ариутгах санитолын хангалт, ариутгалын бодисын нөөц, ажлын байранд мэргэжлийн байгууллагаар шавжгүйтгэл, халдваргүйтгэл хийлгэсэн байдалд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

Мөрөн нисэх буудал, Зооноз өвчин судлалын төвтэй хамтран 2020 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс 2020 оны 5 дугаар сарын 16-ны өдрүүдийн Мөрөнгөөс

Улаанбаатар чиглэлийн нислэгээр явсан 322 хүн, Улаанбаатараас Мөрөн чиглэлийн нислэгээр ирсэн 232 хүнээс асуумж судалгаа авч, тандалт хийлээ. Мөн коронавируст халдварын үед орон нутгийн нислэгээр зорчих зорчигчдийн эрүүл мэндэд хяналт тавих түр зааврын дагуу Увс-Мөрөн-УБ, Ховд-Мөрөн-УБ чиглэлд зорчиж байсан 606 хүний халууныг агаарын хөлөгт хэмжиж биеийн байдалд хяналт тавьж ажиллаа.

Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд:

Эх хэлний онлайн наадам, Сүегэр уран бичлэгийн уралдааныг мэргэжлийн багш, насанд хүрэгчид, сурагчид гэсэн ангиллаар зохион байгуулав.

Төгсөлтийн бичиг баримт олгох бэлтгэл ажлын зөвлөмж, хичээлийн жилийн тайлан бичих зөвлөмжийг сургууль, цэцэрлэгт өгөв. Аймгийн тэргүүний сурагчдыг шалгаруулж, шагналыг олголоо. Сайн сурагч- 1-р ангийн унших чадварын үнэлгээ хийлээ.

2020 оны 5 сард хөдөө орон нутгийн сургууль, цэцэрлэг, боловсрол, соёлын байгууллагын үйл ажиллагаатай танилцаж зөвлөмж, чиглэл өгөв.

2021 Хөвсгөл аймгийн номын санч нарын дунд Манай сумын бахархал номын үзэсгэлэнг цахимаар зохион байгууллаа.

2020 оны 5 сарын 9-25-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн 20 сумын сургууль цэцэрлэг соёлын төвийн үйл ажиллагаатай танилцаж зөвлөн тусаллаа.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Дэлхий нийтэд тархаад байгаа цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх зорилготой “КОВИД-19 цар тахлын халдварын үеийн харилцан ажиллагаа, хариу арга хэмжээний дадлага сургууль” 2020 оны 05 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулагдлаа. Уг дадлага сургуулилтад Хөвсгөл аймгийн Онцгой комисс, Шуурхай штаб, гамшгаас хамгаалах албад, тусгай болон ерөнхий зориулалтын мэргэжлийн анги, 23 сум 1 тосгоны нийт 260 албан хаагч оролцлоо.

Эрүүл мэндийн газраас осол гэмтэл, өсвөр үеийн нийгэм, сэтгэл зүйн эрсдлээс сэргийлэх, бага насны хүүхдийн эмнэлгийн бус эндэгдлийг бууруулах зорилгоор Аймгийн прокурорын газрын ерөнхий прокурор, Цагдаагийн газрын дарга, Шүүх шинжилгээний албаны дарга, Нэгдсэн эмнэлгийн сэтгэл судлаач нарыг оролцуулан уулзалт зохион байгууллаа.

АШУҮИС-ийн харьяа Дархан-Уул аймаг дахь анагаах ухааны сургуулийн шаталсан бакалаврын ангийн оюутнуудын тайлан хамгаалалт, туслах сувилагчийн ангийн төгсөлтийн улсын шалгалтыг орон нутагт амжилттай зохион байгууллаа. Туслах сувилагч нар онолын болон дадлага шалгалт өгч нийт 32 туслах сувилагч хамрагдлаа.

Эрүүл мэндийн газраас Олон улсын сувилагч нарын баярын өдрийг тохиолдуулан “Сувилагч танд баярлалаа” сэдэвт талархлын захидал бичих уралдааныг зохион байгууллаа.

Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс томилогдсон магадлан итгэмжлэлийн шинжээч нар Бүрэнтогтох, Жаргалант, Хатгал Ренчинлхүмбэ сумдад магадлан итгэмжлэлийн үнэлгээ хийж зөвлөн туслаж ажиллаа. Мөн Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамжийн дагуу Эрүүл мэндийн газрын хяналт үнэлгээний баг Аймгийн Нэгдсэн эмнэлэг, Арбулаг, Баянзүрх Улаан-Уул, Ренчинлхүмбэ, Цагааннуур, Тосонцэнгэл, Их-Уул, Рашаант, Тариалан сумдад хяналт үнэлгээ хийн зөвлөн туслаж ажиллалаа.

Хөдөлмөр, халамжийн чиглэлээр:

30244 иргэнд 14 төрлийн халамжийн үйлчилгээг үзүүлж 2,6 тэрбум төгрөгийг халамжийн сангаас зарцуулсан байна.

2020 онд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжиж байгаа санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд хамрагдахаар нийт 338 иргэний төсөл ирснээс 196 иргэний төслийг 737,000,000 төгрөгөөр дэмжихээр шийдвэрлэсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд 31 иргэнийг хамруулж ХЭДС-аас 88 сая төгрөгний санхүүжилтыг зарцуулсан.

Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг арга хэмжээнд өрхийн үйлдвэрлэл эрхэлдэг ахмадыг хамруулж ХЭДС-аас 27 сая төгрөгийг зарцуулсан.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын чиглэлээр:

Газрын дэргэдэх “Нэг цэгийн үйлчилгээний төв”-д дараах байдлаар үйлчилгээ үзүүлсэн байна.

Үүнд:

Холбон зуучлах үйлчилгээ нийт 19, насанд хүрэгч 15, хүүхэд 4

Эрүүл мэндийн үйлчилгээ нийт 11, насанд хүрэгч 5, хүүхэд 6

Гэр бүлд эргэн нэгтгэгдсэн нийт 4, насанд хүрэгч 2, хүүхэд 2

Хууль, эрх зүйн зөвлөгөө нийт 71, насанд хүрэгч 58, хүүхэд 13

Хүүхэд хамгааллын үйлчилгээ нийт 14, эрэгтэй 5, эмэгтэй 9

Сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээ нийт 29, насанд хүрэгч 19, хүүхэд 10

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ насанд хүрэгч 8, хүүхэд нийт 12 хүн байрлаж хамгааллын үйлчилгээ авсан байна.

Гаднаас 45 хүнд, 147 удаагийн үйлчилгээг хүргэж ажилласан байна. Төвийн 70382121 утсыг 24 цагаар тогтмол ажиллуулж ирсэн дуудлагын дагуу шаардлагатай үйлчилгээг хүргэж холбогдох байгууллагад холбон зуучлан

эрсдэлтэй болон аюулын зэрэг өндөр гарсан тохиолдолд аюулгүй байдлын хамгаалалтанд авч ажиллаж байна.

Хүүхдийн тусламжийн 108 утасны дуудлага мэдээлэл 2020 оны 4 дүгээр сарын 21-нээс 5 дугаар сарын 18-ны өдөр хүртэлх хугацаанд нийт Хөвсгөл аймагтай холбоотой 18 дуудлага бүртгэгдсэн. Үүнд: Мөрөн сум-11, Галт-1, Улаан-Уул-1, Бүрэнтогтох-1, Их-Уул-1, Алаг-Эрдэнэ-2, Тосонцэнгэл-1 байна. Тухайн дуудлагыг харьяа хамтарсан баг болон газрын мэргэжилтнүүд хамтран асуудлыг тодруулж, хариу үйлчилгээ үзүүлж байна.

“Сайн дурын ажилтан бэлтгэх” цахим сургалтанд хамрагдлаа. Газрын дэргэдэх Залуучуудын хөгжлийн төв нийт 36 сайн дурын ажилтныг бүртгэсэн. Сайн дурын үйл ажиллагааны онцлог, сайн дурын үйл ажиллагааг зохион байгуулах үе шат, сайн дурын ажилтны ёс зүй чиглэлээр сайн дурын ажилтнуудыг бэлтгэх зорилгоор засгийн газрын хэрэгжүүлэгч агенлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулагдсан цахим сургалтанд ЗХТ-ийн 3 мэргэжилтэн, 9 сайн дурын залуус хамрагдлаа.

“Гэр бүлдээ талархъя” захидлын уралдаан зохион байгуулав. Олон улсын гэр бүлийн өдрийг угтан гэр бүлийнхээ хэн нэгэнд талархлын үгээ захидлаар дамжуулан хүргэж гэр бүлийн халуун дулаан уур амьсгал бүрдүүлэх зорилгоор “Гэр бүлдээ талархъя” цахим захидлын уралдааныг 2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдрөөс 2020 оны 5 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд зохион байгуулав. Тус уралдаанд 52 оролцогч захидлаа ирүүлснээс 5 захидлыг шалгаруулж олон улсын гэр бүлийн өдрөөр өргөмжлөл, гэр бүлийн номын багц, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан.

2020 оны 5-р сарын 3-нд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын Залуучуудын хөгжлийн газар, НҮБ хамтран “Аж үйлдвэрийн технологи, Moodle програм дээр хэрхэн ажиллах талаар сургалт орлоо. Сургалтыг НҮБ-ын аж үйлдвэрийн сургалт хариуцсан ажилтан н.Цэцэг-Өлзий удирдан явуулж цахим сургалтанд 21 аймаг, 9 дүүргийн залуучуудын хөгжлийн төвийн мэргэжилтнүүд хамрагдсан ба Хөвсгөл аймгаас Залуучуудын хөгжлийн төвийн 3 мэргэжилтэн бүрэн хамрагдлаа.

“Зүтгэл илтгэл санаачилга”-ийг дэмжих нэрлэсэн жилийн хүрээнд гэр бүл болон залуучуудын дунд 2 төрлийн болзолт уралдаан зохион байгуулагдаж байна.

Сумдын Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлүүдэд ажлын чиглэл, зөвлөмж хүргүүллээ. Сумдын залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн 2020 онд ажиллах ажлын чиглэл буюу “Залуусын төлөө салбар зөвлөл” болзолт уралдааны удирдамж хүргүүллээ. Болзолт уралдааны тайлан 11 дүгээр сарын 10-нд ирүүлэх юм. Мөн Хөвсгөл аймгийн залуучуудын аж байдлыг нэгдсэн судалгаа гаргах зорилгоор авч

байгаа судалгааны асуумж хүргүүлээ. Тус судалгааны асуумжийг сумын ЗХСЗ байгуулагдсан тушаал шийдвэрийн дагуу 5 дугаар сарын 30-ны дотор ирүүлэх юм.

“Тайван амьдрал танай гэрээс” сургалтыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байна. Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж шүүхийн шийдвэрээр баривчлагдсан нийт 70 иргэнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, хүүхэд хамгаалал, гэр бүлийн үнэ цэнэ, хорт зуршил, хүүхэд хүмүүжлийн эерэг арга, сэтгэл зүйн оношлогоо, амьдрах ухааны модуль сургалтуудаар мэдээ мэдээлэл, зөвлөмж өгч ажиллав.

Нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулав. Олон улсын гэр бүлийн өдрийг тохиолдуулан Цагдаагийн газартай хамтран Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж шүүхийн шийдвэрээр баривчлагдах хугацаа дууссан 5 иргэдийн гэр бүлд нөлөөллийн ажил зохион байгуулав.

“Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” цахим уралдааныг зохион байгуулав. “Хүүхэд эрхэм хэрэглэгч” аяны хүрээнд “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” цахим уралдааныг 2020.03.15-2020.04.20 –ны хооронд аймгийн Боловсрол, соёл урлагийн газар , ДЗМОУБ хамтран зохион байгуулж ажиллав.

Хүүхэд, гэр бүлд нийгэм–сэтгэл зүйн анхны тусламж үзүүлэх нь цахим сургалтанд хамрагдав. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Японы хүүхдийг ивээх сантай хамтран зохион байгуулж байгаа САТ буюу хүүхэд, гэр бүлд нийгэм–сэтгэл зүйн анхны тусламж үзүүлэх нь цахим сургалтанд 2020 оны 4 дүгээр сарын 20- 5 дугаар сарын 06 хүртэлх хугацаанд зохион байгуулагдлаа.

Цэргийн танхимыг бий болгов. Хүүхэд, өсвөр үе залуучуудын эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэх зорилгоор аймгийн хүүхдийн ордонд Монгол улсын цэргийн түүхэн замнал, цэргийн хэрэгслээр танхим нээхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

“Гэр бүлдээ талархъя” цахим уралдааныг зохион байгуулав. Олон улсын гэр бүлийн өдрийг угтан гэр бүлийнхээ хэн нэгэнд талархлын үгээ захидлаар дамжуулах хүргэж гэр бүлийн халуун дулаан уур амьсгал бүрдүүлэх зорилгоор “Гэр бүлдээ талархъя” цахим уралдааныг зохион байгуулж дүгнэлээ. Тус уралдаанд 52 оролцогч захидлаа ирүүлсэнээс 5 захидалын шалшаруулж өргөмжлөл, гэр бүлийн номын багц, мөнгөн шагналаар шагнаж урамшуулав.

“Амьдрах ухааны чадвар олгох” цахим хичээлийг бэлтгэв. Өсвөр үе, залуучуудын өдөр тутмын амьдралд тохиолдох хэрэгцээ шаардлага, хүндрэлүүдийг үр дүнтэйгээр шийдэх, тэдгээрт зохицох боломж олгох амьдрах ухааны чадвар нөлөөллийн үйл ажиллагааг хүргэх зорилгоор “Амьдрах ухааны чадвар” багц 12

модулиар цахим сургалтыг бэлтгэн иргэд олон нийтэд хүргэх арга хэмжээ зохион байгуулагдлаа.

“Хүүхдийн ертөнц-2020” гар зургийн уралдааныг зохион байгууллаа. “Хүүхдийн ертөнц-2020” гар зургийн цахим уралдааныг цэцэрлэгийн нас 4-6 нас, сургуулийн бага нас 1-5-р анги, 6-9-р анги 10-12-р анги гэсэн 4 насны ангиллаар “Мөрөөдөл” сэдвийн хүрээнд 5-р сарын 20-ны өдрийг хүртэл зохион байгуулав. Уралдаанд 4 насны ангилалд 121 бүтээл оролцлоо.

- “Хүрэл тулга-2020” яруу найргийн наадмыг цахимаар зохион байгуулж байна.
- Хүүхдийг сонсох “Хүүхдийн анд” цахим группыг ажиллуулж байна.

Хүүхдийн оролцох эрхийг хангах, хүүхэд өөрийн эрх ашигт нөлөөлж байгаа аливаа асуудлаар шийдвэр гаргах үйл явцад сайн дурын үндсэн дээр оролцох бололцоог бий болгох зорилгоор “Хүүхдийн анд” цахим санал хүсэлтийн фэйсбүүк группыг ажиллуулж байна.

Соёлын чиглэлээр:

Нийтийн номын сангаар 731 уншигч ирэгсэдэд 257 ширхэг ном хэвлэлийн бүтээгдэхүүнээр үйлчилсэн байна.

Номын үзэсгэлэн мэдээлэл Аймгийн нэрлэсэн жил ЗИС, Хүүхэд итгэлийн харц – 2 аяны хүрээнд шинэ болон сэдэвчилсэн номын үзэсгэлэн 8 удаа танхимд гаргаж, “Хөвсгөл төв номын сан” пэйж хуудсаар сурталчиллаа. “Цахим уншлагад нэгдэцгээе” уриан дор 94-н нэр төрлийн хүүхдийн зохиолуудыг цахимаар оруулж бүтээлийг онлайн орчинд сурталчиллаа.

“Хүүхэд итгэлийн харц” аяны хүрээнд хөл хорионы үед гэртээ байгаа хүүхдүүд болон иргэдэд “Тэгш байдлын төлөөх музей: Олон янз байдал ба тэгш хамруулах уриатай Олон улсын музейн өдөрт зориулсан зурагт хуудсыг тараан өөрсдийн харах өнцгөөр будууллаа.

“Хүүхэд –Итгэлийн харц” аян цахим музей ажлын хүрээнд ЕБС-ын түүх нийгмийн багш нартай хамтран орон нутаг судлал түүх соёлын өвийг сурталчилан танилцуулж байна. Энэ удаагийн дугаарт Сод-Эрдэм сургуулийн түүх нийгмийн багш Д.Батсүх болон ДМЦ сургуулийн газарзүйн багш Р.Хишигбуян багшийг урьж оролцуулан төгсөх ангийн сурагчдад мэргэжил сонголтын талаар сонирхолтой яриа өрнүүлж, цахим ажил зохион байгууллаа.

“Хүүхэд итгэлийн харц” аяны хүрээнд хүүхдүүдэд мал аж ахуйтай танилцуулах зорилгоор Бүрэнтогтох сумын Туяа багийн малчин С.Бямбасүрэнгийн очиж мал төллүүлэх болон өдөр тутмын ажилтай танилцаж, мал аж ахуйтай холбоотой мэдээллээр видео бичлэг хийж олон нийтийн сүлжээнд байршуулав.

“Зүтгэл –Итгэл –Санаачлага” нэрлэсэн жилийн хүрээнд Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театрын уран бүтээлчид зургаан ястаны ардын урлагийн тоглолтыг цуврал хэлбэрээр цахимаар дамжуулан үзэгчдийн хүртээл болгов.

Үндэстний контентийг бий болгох зорилгоор “Хугашхан” баатрыг амилуулсан. “Хугашхан” баатар аа олон нийтэд таниулахын тулд нийгмийн сүлжээгээр цуврал нэвтрүүлэг бэлтгэж хүргэсэн.

Тав дугаар сард “Хугашхан” баатар нь ХДТ –ын хөгжмийн анги, драмын анги, дууны анги, бүжиг ангиудаар явж тус ангиудын онцлогийг харуулсан нэвтрүүлэг бэлтгэж хүргэжээ.

Тав. Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

ХХААХҮЯ-наас 2 удаагийн хуваарилалтаар 12 нэр төрлийн 6 256 749 төгрөгний үнэ бүхий хүнсний ногооны үрийг татан авч 20 суманд хуваарилан олголоо.

Жил бүрийн 5 дугаар сарын эхний 7 хоногийг “Хөрс хамгаалах өдөр” болгон зарласантай уялдуулан ХХААХҮЯ-наас ирүүлсэн чиглэлийн дагуу “Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн хамгийн үнэт зүйл бол “Үржил шим сайтай эрүүл хөрс + чанар сайтай үр” , “Хөрс нь эрүүл шимтэй - Хүнс нь эрүүл тэжээллэг - Хүн ард маань эрүүл чийрэг байг - Хөрсөө хамгаалцгаая” гэсэн агуулаг бүхий мэдээлэл, хөрс хамгаалах шторкийг “Хөвсгөл аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар” пэйж хуудсанд байршуулан сурталчилж 49 иргэнд уг мэдээлэл хүрсэн байна.

Сумдаас хүн амын хэрэгцээнд нийлүүлэгдэж байгаа гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний худалдааны цэг салбарт байгаа үлдэгдлийн мэдээг долоо хоног бүр авч нэгтгэн ХХААХҮЯ-ны ХҮХБЗГ-т хүргүүлж ажиллаа. 2020 оны 5 сарын 27-ны өдрийн мэдээгээр гурил 684,3 тн, мах 127,4 тн, будаа 94,5 тн, элсэн чихэр 88,1 тоннын үлдэгдэлтэй байгаа бөгөөд энэ нь аймгийн нийт жишсэн дундаж хүн амаар тооцвол гурил 63 хоног, мах 10 хоног, импортын бүтээгдэхүүнүүд 2-25 хоногийн нөөцтэй байна.

“Хоршоог хөгжүүлэх нийгмийн арга хэмжээний хөтөлбөр 3”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ХХААХҮЯ-ны ЖДҮХБЗГ-аас Монголын хоршоологчдын нэгдсэн холбоотой хамтран сумдын хоршоо хариуцсан мэргэжилтнүүдэд “Хоршоог үнэлэх үнэлгээний арга зүй”-н сэдвээр нэг өдрийн сургалт зохион байгуулж уг сургалтад 15 сумын мэргэжилтэн танхимаар, 7 сумын мэргэжилтэн онлайнгаар хамрагдлаа.

Жижиг дунд үйлдвэрлэлийн дэмжих сангаас зээл олгох төсөл хүлээн авах зарыг 2020 оны 04 дүгээр сарын 230-ны өдрөөс 05 дугаар сарын 19-ны өдрийн пэйж хуудсанд байршуулан ажилласнаар нийтдээ 3681 хүнд мэдээлэл хүрсэн ба Хөвсгөлийн өнгө, Түмний телевиз, Хөвсгөл телевизүүдээр тус тус түгээж энэ хугацаанд жижиг дунд үйлдвэр эрхлэгчийн тодорхойлолтыг 22 аж ахуйн нэгжид өгч, төслийн болон ноолуурын талаарх мэдээллийг 45 иргэнд утсаар өгч ажиллаа.

Жижиг дунд үйлдвэрлэлийн дэмжих сангаас зээл олгох төсөл хүлээн авах хугацааг журмын дагуу 5 дугаар сарын 19-ны өдрийн 17.30 минутаар тасалбар болгон дуусгаж төсөл авах хугацаанд 4 тэрбум 125 сая.төгрөгийн зээл хүссэн 44 төслийг хүлээн авлаа. Үүнд хөдөө орон нутгаас 21 аж ахуйн нэгж, аймгийн төвийн 23 аж ахуйн нэгж төсөл ирүүлж төслийг битүүмжилсэн хэлбэрээр хүлээн авлаа.

Төл бойжилтын талаар:

Хөвсгөл аймгийн хэмжээнд 2020 оны 5 сарын 21-ны байдлаар оны эхний 2689,6 мян.толгой хээлтэгч мал төллөхөөс 1446110 нийт толгой хээлтэгч төллөснөөс ингэ 165, гүү 26476, үнээ 71127, эм хонь 860637, эм ямаа 487705 мал төллөж байна. Нийт 1307871 толгой төл бойжиж үүнээс ботго 154, унага 25307, тугал 68754, хурга 768034, ишиг 445622 толгой байна. Төллөлтийн хувь 68.2 төл бойжилт 93.4 хувьтай байна.

Оны эхнээс 248889 толгой том мал хорогдож үүнээс тэмээ 4, адуу 7212, үхэр 16298, хонь 135446, ямаа 89929 мал хорогдож үүнээс хээлтүүлэгч нийт 763 үүнээс азарга 33, бух 122, хуц 297, ухна 311, өвчнөөр нийт 373, адуу 27, үхэр 43, хонь 150, ямаа 153 мал хорогдож оны эхний нийт малаас 4.1 хувь нь хорогдсон байна. Хээл хаясан хээлтэгч ингэ 1, гүү 525, үнээ 660, эм хонь 13156, эм ямаа 63665 нийт 78007 толгой хээлтэгч хээл хаясан байна.

Цагаан-Уул, Цэцэрлэг, Бүрэнтогтох, Шинэ-Идэр, Жаргалант, Баянзүрх сумдад бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготной тэмцэх ажил хийгдэж байна.

Манай аймгийн Цагаан-Уул, Цэцэрлэг, Бүрэнтогтох, Шинэ-Идэр, Жаргалант, Баянзүрх сумдын 393,9 мянган га талбайд бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготно тархсан. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2020 оны А-89 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2020 оны А/228 дугаар захирамжаар Улсын төсвийн хөрөнгөөр 60,0 мянган га бэлчээрийн талбайд тэмцэх ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Дээрх 6 суманд нийт 497 малчид иргэдтэй гэрээ хийж,120 төрийн албан хаагчдыг дайчилгаагаар ажиллуулж, шувууны үүр, суудал хийх, утах, конус тавих, ус цутгах зэрэг энгийн механик аргаар тэмцэж байна.

Малчдад тушаасан ноолуурын кг тутамд нь 20 мянган төгрөгийн урамшуулал олгох ажлын хүрээнд 23 сум 1 тосгоны 18.507 өрхийн овог нэр, регистрийн дугаар, дансны дугаарыг нэгтгэн авч Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Мал хорогдолын талаар: Энэ сард аймгийн хэмжээнд А/03-1, А/17-1, В/03-1, С/01-3 удаа халдварт өвчин оношлогдож, 10 мал, амьтан өвчилж, 10 мал хорогдсон байна.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээнд нийт 1487,7 сая толгой мал амьтан хамрагдахаас 223,2 мянган толгой мал хамрагдаж гүйцэтгэл 15 хувьтай байна.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 1 сумын 5 багийн 232,0 мянган толгой малд зайлшгүй шаардлагаар хийх Мал эмнэлгийн ерөнхий газрын шийдвэрийн дагуу Рашаант сумын Засаг даргын 2020 оны 5 дугаар сарын 11-ны өдрийн А/47 тоот захирамжаар 5 багийн 621 өрхийн 229142 толгой мал хамрагдаж гүйцтгэл 99,4 хувьтай дуусгалаа.

Малын хорогдлын мэдээг 7 хоног бүрийн пүрэв гаригт сумын мал эмнэлгийн тасгаас авч нэгтгэн холбогдох байгууллагуудыг мэдээллээр ханган ажиллаж байна. Аймгийн хэмжээнд 24-н суманд нийт 250294 мал хорогдсоноос 23680 буюу 9,4 хувь нь бод, 226614 буюу 90,6 хувь нь бог мал байна. Монгол улсын ерөнхий сайдын 01 албан даалгавар, Аймгийн засаг даргын А/122 тоот захирамжийн дагуу нийт 250521ш мал, амьтны сэг зэмийг устгаж, 777534м2 талбайд халдваргүйжүүлэлт хийж бүгд 43258473,0 төгрөг зарцуулсан байна. Үүнд: аймгийн Засаг даргын Тамгын газраас 5 сая төгрөг, мал эмнэлгийн ерөнхий газраас 14,4 сая төгрөг, сумын касаг дарын тамгийн газраас 13,1 сая төгрөг, бусад хэрэглэгдэхүүнд 10,8 сая төгрөгийг зарцуулсан байна.

Манай аймгийн 23 сум, 1 тосгоны мал эмнэлгийн тасагт ажиллаж байгаа орон нутгийн мэргэжилтнүүдийн ажиллах нөхцлийг сайжруулах, Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, нийтийн эрүүл мэнд, хүнсний аюулгүй байдлыг сахин хамгаалахад дутагдалтай байсан Мал эмнэлгийн үйлчилгээний машин, сумын мал эмнэлгийн тасагт мотоцикл, иж бүрэн компьютер, оффисын тавилга, лабораторид сүүний чанар шалгах лактоскан зэрэг нийт 143,2 сая төгрөгийн техник, төхөөрөмжийг олголоо.

Зургаа.Байгаль орчин, үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд:

Дэлгэрмөрөн голын сав дагуу хууль бусаар олборлож байгаа хайрга дайрганд Мөрөн сумын ЗДТГ, МХГ-тай хамтарсан хяналт шалгалт хийв.

Аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран “Хайрын мод” аяныг хэрэгжүүлэх, “Аялал жуулчлалын бүс нутагт хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” чиглэлээр эрх зүйн орчинг бий болгох зэрэг ажлуудыг “Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр”-ийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын удирдамж батлуулж, Хайрын мод аяны хүрээнд Засаг даргын удирдамжийн дагуу Залуу гэр бүл, ахмад настан, Эрсдэлтэй айл өрхөд тус тус 3,3 ш мод тарих үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Бүх нийтээр мод тарих ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, хот хоорондын авто замын дагуу мод тарих ажилд оролцов.

Эрх чөлөө сонин, Хөвсгөл телевиз, сумдын ЗДТГ-т “Ногоон зээлийн” талаар мэдээлэл хүргүүлж сурталчилан ажиллаж байна.

Хөвсгөл аймгийн 10 бахархлын танилцуулгыг бэлтгэж, БОАЖЯ, аялал жуулчлалын мэдээ, мэдээлэл нээлттэй группт байршуулж сурталчилан ажиллаж байна.

Мод боловсруулах үйлдвэрийн газар сонгох ажиллаар Цагаан-Үүр, Эрдэнэбулган суманд ажиллав.

Байгаль орчны үнэлгээний мэдээллийн санд “City” авто угаалгын байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг орууллаа.

Мөрөн сумын Байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч нартай хамт “Хөвсгөл хүнс” ХХК-ийн шинээр хэрэгжүүлэх гэж буй загас үржүүлгийн газарт очиж хяналт шалгалтын ажлыг хийсэн. Мөн замаараа Сити авто угаалгын газарт орчны 50 м бүс доторх хог хаягдлыг тогтмол цэвэрлэж байх тухай санамж өглөө.

Эцэг эх, хүүхэд гэр бүлийн зөвлөлөөс санаачлан “Лантуун богц” аянд нэгдэж амьдралын боломж тааруу ядуу хүүхдүүдэд хүнсний бүтээгдэхүүн мөн мөнгөн хандив өгч аяныг зохион байгууллаа.

“Хөрс хамгаалах өдөр”-г зориулж зарласан гар зургийн уралдааныг мэргэжилтнүүдээр шүүлгэж шагналт байруудыг шалгаруулж ажилласан.

Хоггүй цэвэрхэн Монгол аяны хүрээнд 4 сард хийсэн ажлын тайланг нэгтгэж, БОАЖЯ-нд хүргүүлэв. Мөн 5 сард “Хоггүй цэвэрхэн Монгол-бидний ирээдүй” уриан дор бүх сумдад олон нийтэд уриалга хүргэх, зөвлөмж чиглэл хүргүүлэн ажиллаж, сумдад бүх нийтийн цэвэрлэгээ хийгдлээ.

Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, хог хаягдлыг дарж булаах зардлын нэгж тарифыг аймгийн ИТХ-ын ээлжит бус 12 дугаар хуралдаанаар хэлэлцүүлээ.

БОАЖЯ-аас “Хоггүй цэвэрхэн Монгол” аяны хүрээнд аймагт хийгдэж буй ажил, гарсан үр дүнгийн талаар нэвтрүүлэг бэлтгэх баг ирж, хамтран нэвтрүүлэг бэлтгэв. Мөн хог хаягдлын менежментийг сайжруулах чиглэлээр БОАЖЯ-аас 50 сая төгрөг хуваарилсны дагуу хийгдэх ажлын төлөвлөгөө, ажлын даалгаврыг бэлтгэн хүргүүллээ. Мөн 2 сарын турш хэвлэл мэдээллээр хоггүй Монгол аяныг сурталчилах зорилгоор хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй гэрээ байгуулах ажил хийгдлээ. Хог хаягдлын тухай хууль шинэчлэгдэж 2017 оноос хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан аймгийн ИТХ, Засаг даргаас хэрэгжүүлэх эрх үүргийн биелэлтийг УИХ-ын гишүүн Сарангэрэлээс ирүүлсэн асуулгын дагуу мэдээг хүргүүлэв.

Аймгийн агаарын бохирдлыг бууруулах дэд хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг ажиллаж, хөтөлбөр, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэлэлцэн, эцэслэж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар оруулахад бэлэн болг